



ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМ






THE WORLD BANK



ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН ЯАМ

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙГ СЭРГЭЭЖ, ТӨРӨЛЖҮҮЛЭХИЙН ТӨЛӨӨХ АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН СТРАТЕГИ





ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМ



THE WORLD BANK



ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН ЯАМ

Монгол Улсын эдийн засгийг сэргээж, төрөлжүүлэхийн төлөөх ажил эрхлэлтийн стратеги



KWPF
KOREA-WORLD BANK
PARTNERSHIP FACILITY

2022 оны 12 дугаар сар

© 2022 Дэлхийн Банк
1818 H Street NW,
Washington DC 20433
Утас: 202-473-1000;
Интернет: www.worldbank.org

Эрхийн зарим хязгаар

Энэ бол Дэлхийн Банкны ажилтнуудын бүтээл бөгөөд тайланд тусгагдсан үр дүн, тайлбар, дүгнэлтүүд нь Дэлхийн Банкны Гүйцэтгэх захирлууд болон тэдний төлөөлж буй засгийн газруудын байр суурийг илэрхийлэхгүй болно. Бүтээлд ашиглагдсан өгөгдлийн үнэн зөв байдлыг Дэлхийн Банк хариуцахгүй.

Эрх ба зөвшөөрөл

Энэхүү бүтээл нь зохиогчийн эрхээр хамгаалагдсан. Дэлхийн банк нь мэдлэгийг түгээн дэлгэрүүлэхийг дэмждэг тул энэ бүтээлийг арилжааны бус зорилгоор, бүрэн эш татсаны үндсэн дээр, бүхэлд нь эсвэл хэсэгчлэн хуулбарлаж болно.

Зохиогчийн эрх, зөвшөөрөлтэй холбоотой асуудлаар дараах хаягаар холбогдоно уу: World Bank Publications, The World Bank Group, 1818 H Street NW, Washington, DC 20433, USA; факс: 202-522-2625; э-шуудан: pubrights@worldbank.org.

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙГ СЭРГЭЭЖ, ТӨРӨЛЖҮҮЛЭХИЙН ТӨЛӨӨХ АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН СТРАТЕГИ¹

Хураангуй

Монгол Улс эдийн засгаа төрөлжүүлж, хүртээмжтэй нийгмийг цогцлооход ажлын байрыг нэмэгдүүлэх асуудал чухал ач холбогдолтой. Монгол Улсын төр, засгийн зүгээс урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”, цар тахлын дараа эдийн засгаа сэргээж, солонгоруулан хөгжүүлэх “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг баталж гаргаад байна. Эдгээр бодлогыг хэрэгжүүлэхэд ажил эрхлэлтийн асуудал чухал байр суурь эзлэх учиртай. Ажлын байр, ялангуяа чанартай ажлын байр нэмэгдэхийн хэрээр иргэдийн амьжиргаа чанаржин дээшилж, ядуурал буурна. Илүү бүтээмжтэй ажлын байр бүтээмж султай ажлын байрыг халж, орлосноор эдийн засгийн хөгжлийг дэмждэг. Хөдөлмөрийн идэвхтэй зах зээл нь иргэдэд илүү өргөн боломж олгодгоороо нийгэмд чухал үр нөлөө үзүүлдэг.

Монгол Улс хөдөлмөрийн зах зээлээ хэрхэн одоогийнхоос идэвхтэй, хүртээмжтэй болгох талаарх ойлголтыг гүнзгийрүүлэх зорилгоор Дэлхийн Банкны зүгээс Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн чиг хандлага, боломж төлөвийг судалж, дүн шинжилгээ хийлээ. Энэхүү судалгаагаар тус улсын макро эдийн засгийн болон бүтцийн өөрчлөлт, хөдөлмөрийн зах зээлийн сүүлийн арваад жилийн хөгжил, төлөвийг судалж, үнэллээ². Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн хувьд урт хугацааны, бүтцийн шинжтэй хоёр томоохон сорилт тулгарч буйг уг судалгаагаар тодорхойлов (Зураг 1). Мөн эдгээр сорилтын цаадах шалтгаан буюу хөдөлмөрийн зах зээлд учирч буй саад тотгорыг ажиллах хүчний эрэлт, нийлүүлэлт, хөдөлмөрийн зах зээлийн функциональ ажиллагаа гэсэн гурван талаас авч үзэв. Энэхүү дүн шинжилгээнд тулгуурлан илүү идэвхтэй, хүртээмжтэй хөдөлмөрийн зах зээлийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Дэлхийн Банкны зүгээс тодорхой стратеги, шийдлийг санал болгож байгаагаа “Ажил эрхлэлтийн стратеги” хэмээх энэхүү баримт бичигт тусган танилцуулж байна.

¹ Энэхүү бодлогын тэмдэглэлийг (овгийн үсгийн дарааллаар (англи эх дээрх)) Батмөнхийн Ундрал, Гордон Бетчерман, Хосэ Луис Диаз Санчес, Ян Хуан, Наталиа Миллан, Норжинлхамын Монголмаа нар Яссер Эл-Гаммал, Себастьян Еккарт нарын удирдлага дор бэлтгэв. Энэ нь Дэлхийн Банкны боловсруулсан “Хөдөлмөрийн зах зээлийн дүн шинжилгээний тайлан”-гийн хураангуй хувилбар бөгөөд Монгол Улсын Эдийн засгийн меморандум (Дэлхийн Банк, 2020) зэрэг Дэлхийн банкнаас гаргасан бусад тайланд тусгагдсан ажлын байр, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой зөвлөмжүүдийг ч бас багтаасан болно. Судалгааг хэрэгжүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлсэн Солонгос улс - Дэлхийн Банкны Хамтын ажиллагааны санд талархал илэрхийлье.

² Зарим тохиолдолд сүүлийн хориод жилийн төлөвийг судалсан.

Зураг 1. Илүү идэвхтэй, хүртээмжтэй хөдөлмөрийн зах зээлийг хөгжүүлэхийн тулд тулгамдаж буй гол асуудал, саад тотгорыг тодорхойлж, бодлогын шийдлээ боловсруулах учиртай.



Эх сурвалж: Дэлхийн Банкны мэргэжилтнүүд хураангуйлж танилцуулав.

Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлд тулгарч буй хамгийн гол сорилтууд нь юу вэ?

Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлд дараах хоёр чухал сорилт тулгарч байгааг Дэлхийн Банкны судалгаагаар тодорхойлов. Үүнд:

Сорилт I: Өнгөрсөн арван жилд бий болгосноос олон, илүүтэй сайн, төрөлжсөн ажлын байрыг шинээр байр бий болгох нь хамгийн чухал сорилт мөн. Хэдий өнгөрсөн хорин жилийн хугацаанд ажил эрхлэлт нэмэгдсэн боловч ажиллах хүчний оролцоог нэмэгдүүлж, ажилгүйдлийг бууруулах хэмжээнд байсангүй. Хувийн хэвшил 2010-2020 онд ажлын байр бий болгоход чухал үүрэг гүйцэтгэсэн ч голчлон цалин багатай салбаруудад ажлын байр шинээр нэмэгдсэн байна. Экспортын бараа бүтээгдэхүүний төрөл зүйл багасаж, байгалийн баялагт тулгуурласан цөөн тооны бараа бүтээгдэхүүнд төвлөрөх болсноор ажлын байрыг хангалттай нэмэгдүүлэх боломж нөхцөлийг хязгаарлажээ.

Сорилт II: Эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн зах зээлд оролцоог дээшлүүлэх, залууст илүү өргөн боломж олгох, хот суурин газрын иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар хөдөлмөрийн зах зээлийн хүртээмжийг сайжруулах шаардлагатай байна. Хөдөлмөрийн насны (15 ба түүнээс дээш насны) хүн амын 60 хүрэхгүй хувь нь хөдөлмөрийн зах зээлд оролцож, ажиллах хүчний оролцооны нийт түвшин болон эмэгтэйчүүдийн оролцооны түвшин аажмаар буурч, ажиллах хүчний оролцоон дахь хүйсийн харьцаа бараг 15 нэгж хувиар зөрүүтэй болжээ. Залуус хөдөлмөрийн зах зээлд шилжих явдал мөн л сайнгүй, ялангуяа боловсрол багатай залуучуудын хувьд оролцоо бага, ажилгүйдэл өндөр байна. Хот суурин газрын ажиллах хүчний оролцоо олон улсын дунджаас доогуур, хөдөө орон нутгийн иргэдийн оролцооны түвшнээс хамаагүй бага түвшинд байна.

Хөдөлмөрийн зах зээлийн эдгээр сорилтын цаана ямар саад хязгаар оршиж байна вэ? Цаашид баримтлах бодлогын чиглэл юу вэ?

Эрэлтийн талын янз бүрийн саад хязгаарууд нь хувийн хэвшлийг илүү эрчтэй, төрөлжсөн, шинэтгэгч чадвартай болж хөгжин, улмаар сайн ажлын байрыг олноор бий болгоход бэрхшээл учруулж байна. Жишээлбэл, тогтвортой хөрөнгө оруулалтыг дэмжихийн тулд макро эдийн засгийн бодлого, төсвийн менежментийг илүү сайжруулах шаардлагатай юм. Улс төрийн тогтворгүй байдал, татварын суурийн гажуудагч, санхүүжилтийн хүртээмж, авлига зэрэг асуудал бизнесийн орчин, үйл ажиллагаанд нь нөлөөлдөг гэж ахуйн нэгжүүд үзэж байна. Цаашилбал, уул уурхайгаас ангид бизнесийн шинэ салбаруудыг хөгжүүлэхийн тулд худалдааг дэмжих, тээвэр логистик, хорио цээрийн стандартыг сайжруулахаас гадна эдийн засгийн үйл ажиллагааны төвлөрөл, бөөгнөрлийн үр шимийг бүрдүүлэхэд саад болж буй өргөн уудам газар нутаг, хүн амын сийрэг суурьшилтай холбоотой сорилтуудыг даван туулахад анхаарах учиртай.

Ажлын байр бий болгоход учирч буй зарим саад тогтор ажиллах хүчний нийлүүлэлттэй холбоотой. Хэдийгээр дээд боловсролтой ажиллах хүчний нийлүүлэлт хангалттай боловч тус улсын боловсрол, сургалтын тогтолцоо нь эдийн засгийг сэргээх төлөвлөгөө, урт хугацааны хөгжлийн бодлогод ач холбогдолтой салбаруудын эрэлт, ур чадварын шаардлагад нийцсэн ажиллах хүчийг хангалттай тоогоор бэлтгэж гаргахгүй байна. Түүнчлэн, төсвийн зардалд нэлээд жин дардаг нийгмийн халамжийн хөтөлбөрийн хүрээнд халамжид хамрагдсан, ажил хийх чадвартай иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн дэмжих арга хэмжээ хангалттай нөлөөгүй байна. Ур чадварын сургалтын тогтолцоог сайжруулж, халамж хүртэгч иргэн хөдөлмөр эрхлэхэд учирч буй саад бэрхшээлийг арилгахад нь дэмжлэг үзүүлдэг болох хэрэгцээтэй байна.

Тодорхой бодлогын шинэтгэл хийснээр хөдөлмөрийн зах зээл дээр ажил хайгч ба ажлын байрны нийцлийг тохируулах, ажилгүй иргэн ажил хөдөлмөрт шилжих үйл явцыг илүү үр дүнтэй болгох боломжтой. Хөдөлмөрийн зах зээлийн ажиллагаа нь иргэнийг таарч тохирох ажлын байртай нь үр дүнтэй холбоход чиглэгдэнэ. Үүний тулд хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн оновчтой мэдээлэл шаардагдана. Түүнчлэн, ажилгүй иргэн, нийгмийн халамжид хамрагдагч болон ажил хайгч иргэдийг ажил хөдөлмөртэй болгохын тулд хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй хөтөлбөрүүдийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлагатай. Одоогийн байдлаар Монгол Улсад хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, хөтөлбөр арга хэмжээг сайжруулж, үйл ажиллагааны аргачлал, чадавхыг нь өнөө үеийн шаардлагад нийцүүлэн шинэ түвшинд гаргах нь хөдөлмөрийн зах зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чухал хувь нэмэр оруулах юм. Үүнээс гадна, хөдөлмөрийн хяналтыг сайжруулан хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалтыг илүү үр дүнтэй болгох, хөдөлмөр эрхлэгчдийг ажилгүйдлээс хамгаалах тогтолцоог боловсронгуй болгох боломжтой.


1. Чанартай ажлын байр бий болгоход эдийн засгийн гадаад, дотоод сорилтууд хүндрэл учруулж байна

Монгол Улсын макро эдийн засгийн орчин нь нас залуу бөгөөд улам боловсролтой болж буй ажиллах хүчнийг шингээхүйц сайн чанарын ажлын байруудыг бий болгох таатай нөхцөлийг бүрдүүлэхгүй байна. Хамгийн гол нь уул уурхайгаас бусад салбарын


үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх таатай орчин бүрдэхгүй байна. Энэ нь өнгөрсөн хугацаанд нөөцийн хуваарилалт түүхий эдийн үнээс хамааралтай байсантай холбоотой. Хөрөнгө оруулалт уул уурхайн салбарт төвлөрөхийн зэрэгцээ ажил эрхлэлт хөдөлмөрийн бүтээмж илүү өндөртэй, арилжаалагдах бүтээгдэхүүний үйлдвэрлэлээс үл арилжаалагдах үйлчилгээний салбар луу шилжиж байна. Байгалийн баялаг арвинтай бусад улс оронтой адил энэхүү баялгийн хараал нь байгалийн баялагт тулгуурладаггүй, бүтээмжийн өсөлт ба ажлын байрны чухал эх сурвалж болдог үйлдвэрлэлийн салбаруудын өрсөлдөх чадварыг бууруулахад хүргэжээ. Уул уурхайн орлого, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг дагаж валютын урсгал асар ихээр нэмэгдэхтэй зэрэгцэн төгрөгийн бодит ханш түүхий эдийн үнэ нэмэгдэх үед чангарч, харин үнэ буурахад суларч байв. Түүхий эдийн үнэ өндөр байх үед ажиллагчдын цалин хурдацтай өссөн нь нь ажил олгогчид уул уурхайд ажиллах хүч татахын төлөөх өрсөлдөөнтэй холбоотой байв. Үүний үр дагаварт, ажиллах хүчний нэгж зардал нэмэгдсэнээр олборлох бус салбаруудын өрсөлдөх чадварт нөлөөлж, хөрөнгө ба хөдөлмөрийн нөөцийг импорттой өрсөлдөхүйц салбар, үйлдвэрлэлээс өөр тийш нь шилжүүлэхэд хүргэжээ. Улмаар эдийн засаг төрөлжих, уул уурхайн бус, бүтээмжтэй, экспортод чиглэсэн салбаруудад ажлын байр бий болгоход сөргөөр нөлөөлсөн байна. Экспорт уул уурхайд хэт төвлөрснөөс гадна (Зураг 2) худалдааны түншийн тоо ч цөөрчээ. Эдийн засгийн цогц байдлын индексээс харвал Монгол Улсын экспортын бүтээгдэхүүний төрөл нь жишиж харьцуулсан бусад орнуудынхаас хамаагүй цөөрч (Хайрцаг 1), 2020 оны байдлаар энэ үзүүлэлтээрээ дэлхийд 111-р байрт эрэмбэлэгдэж байна.

Зураг 2. Монгол Улсын экспортын сагсыг эрдэс бүтээгдэхүүн голчлон бүрдүүлж, экспортын төрөлжилт нь цөөрсөөр байна.

а. Монгол Улсын 2019 оны экспорт



б. Экспортын төрөлжилт, 2000-2019



Эх сурвалж: Эдийн засгийн цогц байдлын атлас (өгөгдлийн сан), Харвардын их сургуулийн Өсөлтийн лаборатори, Кэмбриж, Массачусетс (татаж ашигласан огноо: 2021 оны 9 дүгээр сар); <https://atlas.cid.harvard.edu/>.

Хайрцаг 1. Харьцуулсан улс орнуудыг хэрхэн сонгосон тухай

Хамгийн түрүүнд Монгол Улстай харьцуулахад нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) нь 150 хүртэлх хувьтай тэнцүү орныг “ойролцоо түвшний улс”-аар (стандарт харьцуулалт), 150-250 хувьтай тэнцүү орныг “эрмэлзэх түвшний улс”-аар (эрмэлзэх харьцуулалт), 250-иас дээш хувьтай орныг “өндөр хөгжилтэй улс”-аар (хэтдээ эрмэлзэх харьцуулалт) тодорхойлов. Дараа нь ийнхүү үүсгэсэн жагсаалтаас өсөлт удаантай орнуудыг хассан. Эцэст нь, байгалийн баялгийн нөөц, эдийн засгийн шилжилт, Ази тивд оршдог газар зүйн байршил, залуучуудын хүн амд эзлэх хувь зэрэг Монголын онцлог шинж чанартай төстэй шинж бүхий улс орнуудыг эдийн засгийн үзүүлэлтүүд, чанарын мэдээлэл ашиглан тодорхойлсон.

Ийнхүү Армени, Азербайжан, Колумби, Тайланд, Вьетнам (ойролцоо түвшний улс); Чили, Казахстан, Малайз, Оросын Холбооны Улс (эрмэлзэх түвшний улс); Австрали, Канад, Эстони, БНСУ (өндөр хөгжилтэй) гэсэн 13 улсыг сонгосон болно. Шигшиж сонгогдсон 13 улсаас наймыг нь Дэлхийн Банкнаас 2020 онд гаргасан “Монгол Улсын эдийн засгийн тойм”-д жишиж харьцуулах орноор авч үзсэн байв.³

Эх сурвалж: Бетчерман, Жалил нар, 2022.
Тайлбар: а. Дэлхийн Банк (2020)

Түүхий эдийн үнийн хэлбэлзэл, макро эдийн засгийн мөчлөг дагасан удирдлагаас үүдэлтэйгээр эдийн засаг тогтворгүйжихийн хэрээр ажлын байр нэмэгдүүлэх, бүтээмж өсгөхөд шаардагддаг тогтвортой хөрөнгө оруулалт дутагдсаар ирсэн. Монгол Улсын макро эдийн засгийн тогтворгүй байдал нь уул уурхайд улам бүр төвлөрч, эдийн засаг түүхий эдийн үнийн хэлбэлзэлд өртөмтгий болсонтой нэг талаар холбоотой. Гэвч нөгөө талаас, Монгол Улсын төсөв, мөнгө, валютын ханшны бодлого буюу макро-эдийн засгийн бодлого нь гадаад цочролыг зөөллөх гэхээс илүүтэй улам дэврээж ирсэн. Жишээ нь, түүхий эдийн үнэ унасан үед валютын ханшийг тогтоон барьж байснаас үүдэн импорт өсөж, урсгал зардлын алдагдал нэмэгдэж, улмаар хугацаа алдсан бодлогын тохируулгыг тэртээ хойно асар их зардлаар хэрэгжүүлсний гороор валютын ханш эрс өсөж байсан. Төсвийн хууль тогтоомж, төсвийн бодлогыг хэрэгжүүлэх институцийн сул чадавх, төсвийн бодлогын байнгын өөрчлөлт нь өнгөрсөн хугацаанд төсвийн бодлогыг цаг ямагт мөчлөг дагасан байдлаар хэрэгжүүлэхэд, тухайлбал, эдийн засгийн тэлэлтийн үед зардлаа өсгөж, ингэснээр эдийн засгийн мөчлөгийг улам өдөөн, хатуу хэцүү цагт хэрэглэх төсвийн хуримтлал үүсгэх боломжийг хязгаарлаж байв. Макро эдийн засгийн тогтворгүй орчны улмаас хувийн хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтаа, тэр тусмаа судалгаа, хөгжүүлэлт, инновацад оруулах хөрөнгөө хумих, хойшлуулахад хүргэсэн. Учир нь макро-эдийн засгийн савлагаатай орчин нь эрсдэл, тодорхой бус байдлыг нэмэгдүүлж, ингэснээр хөдөлмөрийн эрэлтийг ч хумьж байв.

Ковид-19 цар тахал, Украин дахь дайн, БНХАУ-ын хилийн хорионы нөлөөгөөр макро-төсвийн байдал улам тогтворгүйжиж, хувийн хэвшилд нэмэлт дарамт ачаалал үүсгэж байна. Цар тахлын оргил үе, хатуу хол хорионы улмаас аж ахуйн нэгжүүд санхүүгийн хүндрэлд орж, зарим нь хаалгаа барьсан.³ Хэдийгээр цар тахлын үеийн хязгаарлалтууд цуцлагдсан ч Хятад Улстай залгаа хил дээр ачаа тээврийн асуудал хүндрэлтэй хэвээр (Хятад улсын “Тэг Ковид бодлого”-ын үр дүн) байгаа нь түүхий эдийн экспорт, уул уурхайн салбарын сэргэлтийг хязгаарлаж, импортын бараа бүтээгдэхүүний үнэ нэмэгдэхэд хүргэжээ.

³ <https://blogs.worldbank.org/developmenttalk/silver-lining-covid-19-crisis-mongolia>

Украинд өрнөж буй дайн байлдаанаас үүдэн импортын бараа бүтээгдэхүүн, ялангуяа хүнс, эрчим хүчний үнэ өсөж, олон улсын худалдааны хориг арга хэмжээ ОХУ-аас импортолдог шатахууны төлбөр тооцоо хийхэд хүндрэл дагуулсаар байна. Өрх, аж ахуйн нэгжийг дэмжих зорилготой төсвийн болон төсвийн шинжтэй зардлын тэлэлт нь төсвийн тогтвортой байдал, урсгал зардлын тэнцэлд нөлөөлж, валютын ханшийг өсгөсөн. Монгол Банкны зүгээс төгрөгийн ханшийг тогтворжуулах зорилгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь гадаад валютын нөөцийг бууруулж, арилжааны банкнууд гадаад валютын борлуулалтыг хязгаарлах үр дагавартай байснаар аж ахуйн нэгжүүдийн мөнгөн урсгал тасалдахад хүргэж байв.

Макро-эдийн засгийн хүндрэл бэрхшээлээс гадна микро-эдийн засгийн саад хязгаарууд ч хувийн хэвлийн хөгжлийг сааруулсан. Хувийн хэвшлийн хөгжилд түлхэц өгөх бизнесийн таатай орчныг хууль эрх зүйн хүрээнд сайн бүрдүүлж ирсэнгүй. Цаг хугацаа шаардсан төвөгтэй зохицуулалт, татварын суурийн гажуудал, өрсөлдөөнгүй ноёрхол, шинээр бизнес эхлүүлэхэд учрах саад бэрхшээлүүд нь сүүлийн үед хувийн хэвшлийнхний өгөөжийг бууруулж, улмаар хувийн хэвшлийнхэн уул уурхайн бус салбарт хөрөнгө оруулах, ажлын байр нэмэгдүүлэх чадавхыг сулруулж байна. Жишээ нь, Дэлхийн Банкнаас 2019 онд хийсэн Бизнес эрхлэлтийн судалгаагаар бизнес эрхлэхэд тулгардаг хамгийн том саад бэрхшээлийг авлига, гааль, худалдааны төвөгтэй зохицуулалт, аж ахуй эрхлэх лиценз, тусгай зөвшөөрөл авахад учирдаг хүндрэл гэж тодорхойлсон байна. Засаглалын үзүүлэлтийн тухайд бол, Монгол Улс Транспаренси Интернайналын Авлигын Индексээр 2019 онд 93-т эрэмбэлэгдэж байсан бол 2021 онд 110-р байрт (дэлхийн 180 орноос) орж уруудан, Колумби, Вьетнам, Армени зэрэг жишиг харьцуулсан орнуудаас нэлээд хол хоцорч явна. Гэхдээ сүүлийн үед зарим нааштай сайн өөрчлөлт хийгдэж байна. Тухайлбал, хөрөнгө оруулагчийн гомдлыг хугацаа алдалгүй шийдвэрлэх зорилготой Хөрөнгө оруулагчийг хамгаалах зөвлөл байгуулах, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулан бизнес эрхлэхэд шаардагдах бүх лиценз, тусгай зөвшөөрлийг нэр зааж тодорхой болгох зэргээр ил тод байдлыг дэмжин, бизнес эрхлэлтийг хөнгөвчлөх, мөн зарим чиглэлийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд шаарддаг лиценз зөвшөөрлийн тоог цөөлөх зэрэг шинэчлэлийг хийж эхлээд байна.

Өрсөлдөөнийг дэмжих эрх зүйн орчин сул, өмчийн эрх мэдлийн хэт төвлөрлөөс шалтгаалж хувийн хэвшилд инновац нэвтрэхэд бэрхшээлтэй байна. Олон салбарт зах зээлийн өрсөлдөөн нэмэгдэж буй. Гэсэн хэдий ч Дэлхийн эдийн засгийн чуулга уулзалтаас гаргасан *Дэлхийн өрсөлдөх чадварын 2019 оны тайланд* Монгол Улсад монополийг хазаарлах бодлого нь үр дүн муутай, зах зээл дээр ноёрхогч компаниудын зүй бус ажиллагаа их гэж хөрөнгө оруулагчид дүгнэдгийг дурдсан байна. Бэртэлсман сангаас хийсэн судалгаагаар бол, эрх баригчид цөөн тооны компанитай концессын гэрээ байгуулах, татаас, хөнгөлөлттэй зээл олгох зэргээр шударга бус өрсөлдөөнд хувь нэмэр оруулдаг хэмээн хувийн хэвшлийнхэн үздэг байна.


Санхүүжилтийн хүртээмж ялангуяа жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн хувьд томоохон сорилт болдог. Дэлхийн Банкнаас 2019 онд хийсэн Бизнес эрхлэлтийн судалгаагаар жижиг, дунд бизнес эрхлэгчдийн зургааны нэг нь санхүүжилтийн хүртээмжгүй байдлыг бизнес эрхлэхэд нь тулгардаг хамгийн том гурван бэрхшээлийн нэг гэж үзсэн байна. Засгийн газрын зүгээс орлого, эд материал (мал г.м), машин тоног төхөөрөмж зэрэг хөдлөх эд хөрөнгө барьцаалан зээл авах эрх зүйн орчныг бүрдүүлсэн (Хөрөнгийн барьцааны тухай хууль тогтоомж болон барьцааны бүртгэл). Мөн Засгийн газрын зүгээс Ковид-19 цар тахлын үед эдийн засгаа дэмжихийн тулд хувийн хэвшилд зээл, зээлийн хүүгийн татаас олгох, зээлийн хэсэгчилсэн баталгаа гаргах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Эдгээр арга хэмжээ нь 2021 онд зээл өсөхөд нөлөөлсөн хэдий ч урт хугацаанд тогтвортой хэрэгжих

боломжгүй, зээлийн хүртээмжийг боомилж байгаа институцийн ба макро эдийн засгийн суурь асуудлуудыг шийдвэрлэж чадахгүй юм. Тэдгээр суурь асуудлууд бол хөдлөх хөрөнгө барьцаалах боломжийг барагтаа ашиглахгүй байгаа, зээлийн мэдээлэл, тайлангийн үр дүнтэй систем бүрдээгүй байдал, зээлийн хүү, шаардлагыг чанга хатуу тогтооход нөлөөлж буй макро-эдийн засгийн тогтворгүй байдал зэрэг юм.

2. Ирээдүйд ажлын байр шинээр бий болгоход эергээр нөлөөлөх таатай нөхцөлүүд оршсоор байгаа ч санаа зовоох асуудлууд хөдөлмөрийн зах зээлд илэрч байна.

Монголын ажиллах хүчин залуу хэвээр байгаа боловч цаашдаа насжилт хурдтай явагдана. Монгол Улс залуучуудын орон хэвээр, ирэх 20 жилд хүн ам зүйн ачаалал бага байх тул хүн зүйн цонхны ашиг тусыг хүртэх боломжтой. Гэхдээ Азийн бусад улсуудын нэгэн адил хүн амын дундаж наслалт хурдтай явагдаж, насжиж буй улсаас (2030) насжилт өндөртэй улс (2055) ⁴ болж хувирахад ердөө 25 жил шаардагдана. Ийм шилжилт явагдахад Их Британид 45 жил, АНУ-д 69 жил, Францад 115 жил шаардагдсан байдаг. (Зураг 3).

Зураг 3. Монгол Улсын хүн ам залуу ч цаашид насжилт хурдтай явагдана.



Эх сурвалж: Дэлхийн Банк 2016.

Тайлбар: АБНУ= Ардчилсан Бүгд Найрамдах Улс; ТЗБ= Тусгай захиргааны бүс. Зураг дээр нийт хүн амд 65 ба түүнээс дээш настны эзлэх жин 7 хувьтай байсан он (насжиж буй улс) ба 14 хувь болж өссөн/ өсөх (насжилт өндөртэй улс) оныг харуулав. НҮБ-аас тодорхойлсон “насжиж буй улс” болон “насжилт өндөртэй улс”-ын босго заагийг ашиглав. Зүүн Ази, Номхон далайн орнуудын хугацааг 5-жилээр бүхэлдсэн болно.

Монгол Улсын хүн амын боловсролын түвшин харьцангуй өндөр, гэхдээ боловсролын чанарын асуудал анхаарал татсан хэвээр. Сүүлийн жилүүдэд насанд хүрэгчдийн боловсролын түвшин дээшилсээр - 25 ба түүнээс дээш насны, дээд боловсролтой хүн


⁴ НҮБ-аас тодорхойлсны дагуу насжиж буй улс ба насжилт өндөртэй улс гэдгийг 65 ба түүнээс дээш насны иргэдийн нийт хүн амд эзлэх жин 7 хувь болон 14 хувиас тус тус давахыг ойлгоно.

амын эзлэх хувийн жин (33 хувь) ойролцоо хөгжилтэй орнуудынхаас харьцангуй өндөр байна. Монгол Улсын орлогын түвшнийг харгалзан үзвэл (дэлхийд 92-т) хүмүүн капиталын индексээрээ дэлхийд харьцангуй дээгүүр буюу 51-д⁵ эрэмбэлэгддэг. Гэвч эзэмшсэн мэдлэгийг харгалзан суралцах дундаж хугацааг тохируулж үзэхэд хүүхэд залуучуудыг ирээдүйд шаардагдах ур чадвартай болгож бэлдэх тал дээр боловсролын чанар хангалттай бус байгааг илтгэж байна.

Ажиллах хүчний оролцооны түвшин доогуур, ажилгүйдлийн түвшин өндөр байна.


2021 оны байдлаар хөдөлмөрийн насны хүн амын (15 ба түүнээс дээш насны) 60 хүрэхгүй хувь нь хөдөлмөрийн зах зээлд оролцдог (Зураг 4.а) дөнгөж тал хувь нь ажил эрхэлж байна. Энэ үзүүлэлтээр Монгол Улс жишиж харьцуулсан бусад орнуудаас нэлээд ард хоцорч байна (Зураг 4.б). Түүнээс гадна, ажиллах хүчний оролцоо сүүлийн арван жилд аажмаар буурсаар, ялангуяа 2017 оноос хойш хөдөөд илүүтэй буурчээ. 15 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн бараг тал нь эдийн засгийн оролцоогүй, хөдөөгийн эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо ч бас буурч байна. Ажилгүйдэл ялангуяа хот суурин газарт, бүрэн дунд болон техник, мэргэжлийн боловсролтой иргэд, залуучуудын дунд өндөр байна. Хэдийгээр ерөнхий боловсролын сургууль төгсөгчдийн дийлэнх нь их, дээд сургуульд орж суралцдаг ч, залуучуудын ажилгүйдлийн түвшин улсын хэмжээний ажилгүйдлийн түвшний үзүүлэлтээс 2.5 дахин өндөр, дээд боловсролтой залуу эмэгтэйчүүдийн бараг тал хувь нь ажил эрхлээгүй, сургуульд суралцаагүй, сургалтад хамрагдаагүй төлөвт байна.

Зураг 4. Ажиллах хүчний оролцоо аажмаар буурсаар харьцангуй доогуур түвшинд очжээ



⁵ Хүмүүн капиталын индекс нь шинээр төрсөн хүүхэд 18 нас хүртлээ хуримтлуулах эрүүл мэнд, боловсролын капиталыг багтаасан үзүүлэлт юм.

б. Монгол Улс ба бусад орнуудын харьцуулалт, 2019 (хувиар)




Эх сурвалж: “а” хэсэг: 2010-2021 оны Ажиллах хүчний судалгааны өгөгдөл ашиглан Дэлхийн Банкны хийсэн тооцоолол (15 ба түүнээс дээш нас) 2010-2021 суурилан тооцоолов. “б” хэсэг: ОУХБСТАТ, Холбогдох улс орнуудын 2019 оны Үндэсний ажиллах хүчний судалгаа, харин Азербайджан улсын 2020 оны судалгааны өгөгдлийг ашиглав.

Тайлбар: Энэ зурагт 15 ба түүнээс дээш насны хүн амын ажиллах хүчний оролцооны түвшнийг үзүүлэв.


Бүтцийн өөрчлөлт явагдаж байгаа нь салбаруудын нэмүү өртөг үйлдвэрлэл, ажил эрхлэлтэд гарч буй өөрчлөлтөөр илэрч байна. Өнгөрсөн хорин жилийн хугацаанд хөдөө аж ахуйн салбарын бодит ДНБ, ажил эрхлэлтэд эзлэх жин буурчээ. 2000 онд ажиллах хүчний бараг тал хувь нь хөдөө аж ахуйн салбарт ажиллаж байсан бол 2018 он гэхэд 25 хувь болж буурсан байна (Зураг 5.а). Түүнчлэн, мөн энэ хугацаанд хөдөө аж ахуйн салбарын нэмүү өртгийн ДНБ-д эзлэх хувь гуравны нэгээс наймны нэг болж буурчээ (Зураг 5.б). 2000 онд нийт ажлын байрны гуравны хоёр нь үйлчилгээний салбарт ногдож байсан бол 2018 онд нийт ажлын байрны талаас илүү нь оногдох болжээ. Энэ хооронд аж үйлдвэрийн салбарын эзлэх жин таван нэгж хувиар өсөж, 2018 онд 20 хувь орчим хувь хүрсэн ч үйлчилгээний салбартай харьцуулахад даруухан өсөлт мөн. Аж үйлдвэрийн салбар дотроос боловсруулах үйлдвэрлэлийн ажил эрхлэлтэд эзлэх жин найман хувиас хэзээ ч давж байгаагүй, харин уул уурхайн салбар эдийн засгийн чухал салбар мөн боловч ажил эрхлэлтэд эзлэх жин нь бага (6-8 хувь) байсаар иржээ.

Зураг 5. Монгол Улсад бүтцийн шилжилт явагдаж байна

а. Нийт ажил эрхлэлтэд эзлэх жин



б. Нийт нэмүү өртөгт эзлэх жин




Эх сурвалж: Дэлхийн Банкны Ажлын байрны групп, Ажлын байр ба бүтцийн өөрчлөлтийн статистик аргачлал, Дэлхийн хөгжлийн үзүүлэлтийн өгөгдлийн сангаас авав.


Бүтцийн шилжилтийг даган хөдөлмөрийн бүтээмж нэмэгдсэнээр эдийн засгийн өсөлтөд ихээхэн хувь нэмэр оруулжээ. Гэвч бүтээмжийн өсөлт капитал-ажиллах хүчний харьцаатай хамааралгүй, бүтээмжийн түвшин өндөр биш байна. 2000-2019 онд бодит ДНБ-ий дундаж өсөлт ажиллах хүчний болон ажлын байрны өсөлтийг давсан. Нэг ажиллагчид ногдох нэмүү өртгөөр хэмжигддэг хөдөлмөрийн бүтээмжийн өсөлт 2003 оноос хойш үеийн эдийн засгийн өсөлтийн гол хүчин зүйл болжээ. Хөдөлмөрийн бүтээмж бүх салбарт дээшилсэн (Зураг 6.а) төдийгүй хөдөө аж ахуйн салбарт хамгийн их өссөн байна. Аж үйлдвэр, үйлчилгээний салбарт ч мөн адил хөдөлмөрийн бүтээмж дээшилсэн боловч бүтээмжийн түвшнийг авч үзвэл хөгжлөөр ойролцоо бусад орнуудынхаас харьцангуй доогуур байна. 1990-ээд оны эхэн үеэс хойш нэг ажилчинд ногдох капиталын хэмжээ үл ялиг нэмэгдсэнээс үзэхэд (Зураг 6.б) хөдөлмөрийн бүтээмж капиталын гүнзгийрэлтээс шалтгаалж өсөөгүй, харин технологийн өөрчлөлт, хөдөлмөрийн илүү үр ашигтай хуваарилалтаас үүдэлтэй байна. Өөрөөр хэлбэл, хэрэв нэг ажилчинд ногдох капитал ялангуяа уул уурхайн бус салбарт нэмэгдвэл хөдөлмөрийн бүтээмж ч дээшилнэ.

Зураг 6. Гурван салбарт хөдөлмөрийн бүтээмж нэмэгдсэн хэдий ч капитал-ажиллах хүчний харьцаа өссөнгүй

а. Нэг ажилтанд ногдох нэмүү өртгийн хэмжээ, салбараар



б. Нэг ажилтанд ногдох капитал ба бүтээгдэхүүн



Эх сурвалж: Финстра, Р.К., Р. Инклаар, М.П. Тиммер нар. 2015.

Ажиллах хүчний эрэлт өнгөрсөн хорин жилд ихээхэн тэлж, хувийн хэвшлийн жижиг аж ахуйн нэгжүүдэд цалинтай ажлын байр нэмэгдсэн нь үүнд голчлон нөлөөлжээ.

Ажил эрхлэлт 2000-2019 онд ойролцоогоор 50 хувиар нэмэгджээ. Үүнд хувийн хэвшил, тэр тусмаа жижиг аж ахуйн нэгжүүдийн өсөлт нөлөөлжээ. 2015 онд нийт аж ахуйн нэгжийн дөрвөн хувь нь 50 хүртэлх тооны ажилтантай байжээ. Цалин, хөлстэй ажил эрхлэлтийн нийт ажил эрхлэлтэд эзлэх жин 10 нэгж хувиар өсөж, 2020 онд 60 хувьд хүрчээ. Улсын салбарт ажиллагсдын тоо буурсан ч нийт дүнд эзлэх жин нь ялангуяа ажлын байр дутагдалтай бүс нутагт өндөр хэвээр байна. Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэр, аж ахуйн нэгжид ажиллагчдын жин нэлээд буурчээ.


Ажил олохоор хөдөө орон нутгаас нийслэлд шилжиж ирэх хөдөлгөөн саараагүй ч нийт ажил эрхлэлтийн өсөлтөд Улаанбаатар хотод байршилтай ажлын байрны эзлэх жин бусад бүс нутагтай харьцуулахад хамаагүй өссөн байна. Дотоод шилжилт

хөдөлгөөн сүүлийн 30 жил идэвхтэй өрнөж, шилжигчдийн ихэнх нь нийслэл Улаанбаатар хотод төвхнөж, ажил эрхлэх боломжоор илүүтэй хангагджээ. 2020 оны байдлаар Улаанбаатарт ойролцоогоор 476,000 хүн ажиллаж, нийт ажил эрхлэгчдийн 43 хувийг бүрдүүлж байна. 2010 онд энэ үзүүлэлт 35 хувьтай байв. 2010-2020 оны хооронд Улаанбаатар хотод ажлын байр 31 хувиар өссөн бол бусад дөрвөн бүсэд ажлын байрны тоо харьцангуй тогтвортой, эсвэл буурч ирсэн байна.

Гэвч шинэ ажлын байрууд голдуу цалин хөлс багатай салбаруудад үүсжээ. 2010-2020

оны хооронд үүссэн ажлын байрны 60 орчим хувь нь худалдаа, боловсруулах үйлдвэр, боловсрол, төрийн захиргаа зэрэг цалин багатай/эсвэл буюу бүтээмж султай салбарт хамаарч байна (Зураг 7). Эдгээр салбарын цалин, хөлсний дундаж нь 2020 оны цалингийн голч буюу сарын 800,000 төгрөг (285 ам. доллар орчим)-өөс бага хэмжээтэй юм. Ажил эрхлэлтэд эзлэх жин харьцангуй өндөр, цалин хөлсний хэмжээ нь бусдаас илүү салбаруудад уул уурхай, барилга, тээвэр логистик, санхүү даатгалын салбар багтаж байгаа бөгөөд эдгээр салбараас дурдсан сүүлийн хоёрт нь л хөдөлмөрийн бүтээмж дунджаас дээш өсөлттэй байжээ. Хөдөө аж ахуйн салбарт бүтээмжийн өсөлт өндөр байсан боловч энэ нь цалин хөлстэй ажил эрхлэлтийг нэмэгдүүлсэнгүй.

Зураг 7. Голдуу цалин, хөлс багатай ажлын байрууд нэмэгдэж, ажлын байрны өсөлт худалдаа, төрийн захиргаа, боловсролын салбарт илүүтэй төвлөрсөн байна.



Эх сурвалж: Ажиллах хүчний судалгаануудын өгөгдөл ашиглан Дэлхийн Банкны хийсэн тооцоолол
 Тайлбар: Бөмбөлгийн хэмжээ 2020 оны нийт ажил эрхлэлтэд эзлэх хувийн жинг илэрхийлнэ. Улаан шугам нь 2020 оны цалинтай ажил эрхлэлтийн голч цалингийн хэмжээг илтгэнэ. “Бусад үйлчилгээ” гэдэгт үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа, өрхийн аж ахуйн нэгжийн ажил олгогчийн үйл ажиллагаа, гадаад улс оронд харьяалагдах байгууллагын үйл ажиллагааг багтаав.

Гадаад шилжилт хөдөлгөөн харьцангуй бага, ихэнхдээ түр зуурын шинжтэй тул “тархи зугтах” үзэгдэл томоохон асуудал болж хувираагүй байна. 2020 оны хүн амын тооллогын дүн мэдээгээр бол, Монгол Улсын нийт хүн амын дөрөв орчим хувь нь гадаадад оршин сууж байна. Энэ хувь харьцангуй тогтвортой байсаар ирсэн бөгөөд орлогын түвшин ойролцоо орнуудын дунджаас доогуур байна. Гадаадад гарч суурьшигчдын дийлэнх нь суралцах (34 хувь), ажил эрхлэх (32 хувь) зорилготой байсан бөгөөд гол төлөв БНСУ, Европын орнууд руу гарчээ. Гадаадад шилжин суурьшигчдын нэлээд хэсэг нь боловсрол сайтай иргэд байна. 2020 оны байдлаар, гадаадад хөдөлмөр эрхэлж буй иргэдийн бараг тал хувь нь (46 хувь) дээд боловсролтой иргэд байна. Гэсэн хэдий ч гадаад шилжин суурьшилтын цар хүрээ харьцангуй бага, ихэнх шилжилт түр зуурын шинжтэй байна. Гадаадад суурьшигчдын дөнгөж 30 хувь нь 5-аас дээш жил гадаадад оршин сууж байна. Боловсрол сайтай монголчууд гадагшаа гарч хөдөлмөр эрхэлж буй нь эх орноо бүрмөсөн орхиж, өөр газар ур чадвараа ашиглан амьдаръя гэхээс илүүтэй орлого олж, хуримтлуулан нутагтаа буцаж ирэх зорилготой нь холбоотой байна. Монголчуудын гадагш чиглэсэн шилжилт хөдөлгөөн эх оронд нь сайн ажлын байр хомсдолтой байгаагаас үүдэлтэй нь анхаарал татаж байна.

Ковид-19 цар тахал Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлд сөргөөр нөлөөлж, эдийн засаг цар тахлын өмнөх үеийн байдалдаа харахан орж сэргээгүй байна. Хөл хорионоос улбаатай (эдийн засгийн идэвхжил суларсан)-гаар 2021 онд 60 000 ажлын байр (ажиллах хүчний 5%) үгүй болжээ. Хот суурин газарт ялангуяа, тээвэр, барилга, мэдээлэл

харилцаа, үл хөдлөх хөрөнгө, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээ, соёл урлагийн салбар илүүтэй нэрвэгдсэн. Гэхдээ хязгаарлалтын арга хэмжээнүүд алгуур цуцлагдаж, засгийн газраас ажлын байр хадгалахад зориулж олгосон дэмжлэгүүд эхэлсний дараа буюу 2021 оны хоёрдугаар хагасаас эхлэн эдийн засаг аажмаар сэргэсэн. Гэсэн хэдий ч 2022 оны хоёрдугаар улирлын хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтүүд цар тахлаас өмнөх үеийн түвшинд хүрээгүй л байна. 2019 оны хоёрдугаар улиралтай харьцуулахад нийт хүн ам ба ажил эрхлэгч хүн амын харьцаа, ажиллах хүчний оролцооны түвшин 2022 оны хоёрдугаар улиралд 2.0 хувь болон 1.5 хувиар тус бүр доогуур байна.

Нэгтгэж дүгнэхэд, Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн чиг хандлагад ахиц дэвшил гарсан ч зарим чухал сорилт бэрхшээл тулгамдсаар байна. Эдгээрээс, урт хугацааны, бүтцийн шинжтэй дараах хоёр сорилтыг бид тодорхойлж гаргалаа. Үүнд:

- 1. Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн хамгийн том сорилт бол өнгөрсөн арван жилд бий болгосноос олон, илүүтэй сайн, төрөлжсөн ажлын байрыг шинээр байр бий болгох явдал юм.** Эрч хүчтэй, бүтээмжтэй, шинэтгэн хөгжих чадвартай, төрөлжсөн хувийн хэвшил л ажлын байрыг нэмэгдүүлнэ. Хувийн хэвшлийг дэмжих төрийн бодлого нь өсөлт, тогтвортой байдлыг дэмжсэн макро эдийн засгийн бодлого, хөрөнгө оруулалт, инновацыг дэмжсэн бизнесийн орчны бодлогоор дамжин хэрэгжих учиртай. Түүнчлэн, бүтцийн шилжилт хийх, эдийн засгийн төрөлжүүлэхэд ч анхаарах учиртай.
- 2. Удаах сорилт нь хөдөлмөрийн зах зээлийн хүртээмжийг сайжруулах буюу эмэгтэйчүүд, хот суурин газрын иргэдийн хөдөлмөрийн зах зээл дэх оролцоог дээшлүүлэх, залууст илүү өргөн боломж олгох асуудал юм.** Монгол Улсын ажиллах хүчний оролцооны түвшин жишиж харьцуулсан бусад улсынхаас доогуур байгаа төдийгүй аажмаар буурсаар байна. Эмэгтэйчүүд, хот суурин газрын оршин суугч, дунд боловсролтой иргэд гэсэн гурван тодорхой бүлгийн иргэдийн оролцоо доогуур байна. Монгол Улсын хүн ам залуу хэвээр, боловсролд оруулсан хөрөнгө оруулалт мэдэгдэхүйц нэмэгдсэний хувьд залуучуудын хөдөлмөрийн зах зээлд гарах шилжилтийг дэмжих асуудал чухал ач холбогдолтой. Гэвч, залуучуудын шилжилт тийм ч сайн үр дүнтэй бус, ялангуяа боловсрол багатай, тэр ч байтугай дээд боловсролтой залуусын дунд ч ажилгүйдэл өндөр байна.

3. Монгол Улсад ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх стратеги

Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлд тулгарч буй сорилтууд олон талт учир шалтгаантай тул тэдгээрийг шийдвэрлэх стратеги нь олон салбарыг хамарсан байх шаардлагатай юм. Дэлхийн Банкны дүн шинжилгээгээр ажлын байрыг нэмэгдүүлэхэд тулгарч буй сорилтуудын учир шалтгаан, илүү хүртээмжтэй хөдөлмөрийн зах зээлийг бүрдүүлэх шаардлагыг ажиллах хүчний эрэлт, нийлүүлэлт, хөдөлмөрийн зах зээлийн функциональ ажиллагаа гэсэн гурван талаас авч үзлээ. Ажлын байрыг нэмэгдүүлэх стратеги нь олон салбарын оролцоог шаардаж, эрч хүчтэй хувийн хэвшил, ур чадвартай ажиллах хүч, ажилтны хамгаалал, үр ашгийг хангасан хөдөлмөрийн зах зээл гэсэн гурван чиглэлийг хамарч байна.

Хүснэгт 1. Ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх стратеги дараах гурван чиглэлээс бүрдэх учиртай

Хамрах хүрээ	Зорилго
Ажиллах хүчний эрэлтийг төрөлжүүлэн нэмэгдүүлэх	Макро эдийн засгийн болон төсвийн удирдлагыг бэхжүүлж, ажлын байр шинээр бий болгох хөрөнгө оруулалтын таатай орчныг дэмжих
	Хувийн хэвшлийн динамик хөгжил, инновацыг дэмжихүйц бизнесийн орчныг бүрдүүлж, илүү чанартай ажлын байруудыг бий болгох
	Уул уурхайгаас бусад салбарын экспортын нэр төрлийг нэмэгдүүлж, хэлбэлзэл багатай шинэ салбаруудад ажлын байр бий болгох
Ажиллах хүчний ур чадварыг дээшлүүлэх	Боловсрол, ур чадварын тогтолцооны чанар, уялдааг сайжруулах
	Нийгмийн халамжид хамрагдсан иргэдийн ажил эрхлэх боломжийг нэмэгдүүлэх
Хөдөлмөрийн зах зээлийн ажиллагааг сайжруулах	Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн цогц тогтолцоог хөгжүүлэх
	Хөдөлмөрийн зах зээлийг идэвхжүүлэх хөтөлбөрүүдийг сайжруулах
	Ажилгүйдлийн даатгалыг боловсронгуй болгож, ажилтны хамгааллыг сайжруулах

Ажиллах хүчний эрэлтийг төрөлжүүлэн нэмэгдүүлэх

Макро эдийн засгийн болон төсвийн удирдлагыг бэхжүүлж, ажлын байр шинээр бий болгох хөрөнгө оруулалтын таатай орчныг дэмжих

Төсвийн тогтвортой байдлыг хангах нь эдийн засгийн болон хөдөлмөрийн зах зээлийн цочролын нөлөөг бууруулах чухал арга хэрэгсэл мөн. *Богино хугацаанд хэрэгжүүлэх бодлого:* Өрийн хэмжээ тэлсэн, төсвийн алдагдал өссөн, валютын ханш ба инфляцын дарамт нэмэгдсэн одоогийн нөхцөлд төсвийн алдагдлыг бууруулах бодлого нь макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах түлхүүр арга хэмжээ мөн. Ялангуяа, засгийн газрын зүгээс хүүхдийн мөнгө, халамжийн мөнгөн тэтгэмжийг зорилтот бүлэгт олгох, тэтгэврийн шинэтгэл хийх зэргээр нийгмийн хамгааллын үр ашигтай тогтолцоог бий болгох, тэвчиж болохуйц төсвийн хөрөнгө оруулалтыг танах замаар төсвийн зардлыг бууруулах боломжтой.

Дунд хугацаанд хэрэгжүүлэх бодлого: Төсвийн хүрээг бэхжүүлэх замаар төсвийн бодлогыг макро-эдийн засгийг эмзэг байдлыг дэврээх биш харин бууруулахад чиглүүлэх хэрэгтэй юм. Нэн ялангуяа төсвийн параметрууд, татвараас зугтаах боломж олгож байгаа заалтуудыг эргэн харж, төсвийн хяналтыг бэхжүүлэх, цаг сайхан үед олсон хөрөнгөө хуримтлуулж, эдийн засаг хүндрэхэд хэрэглэх төдийгүй ирээдүй хойч үеийн хэрэгцээнд үлдээхэд анхаарах нь зүйтэй. Түүнчлэн, Засгийн газрын зүгээс төслийг ач холбогдлоор нь эрэмбэлэн сонгох замаар төсвийн хөрөнгө оруулалтын (төр-хувийн хэвшлийн түншлэлд суурилсан төслүүд ч энд багтана) удирдлагыг сайжруулах, төрийн албаны цалингийн тогтолцоог шинэчлэхийн зэрэгцээ

цалингийн санг хэт өсгөлгүйгээр төрийн албаны үр ашгийг дээшлүүлэх, татварын суурийг өргөжүүлэх, орон нутгийн түвшинд цуглуулах татварыг нэмэгдүүлэх замаар уул уурхайн-бус орлогыг өсгөх арга хэмжээг авч хэрэгжүүлэх хэрэгцээтэй байна.

Төсвийн хэмнэлт, мөнгөний арай хатуу бодлогыг хамтад нь хэрэгжүүлж, валютын ханшны өсөлт, инфляцын дарамтыг бууруулах боломжтой. *Богино хугацаанд хэрэгжүүлэх бодлого:* Инфляцын дарамтыг бууруулах, үндэсний валютад итгэх итгэлийг сэргээхийн тулд Төв банк бодлогын хүүгээ нэмсэн ч энэ арга хэмжээний үр нөлөөг төсвийн болон төсвийн шинжтэй арга хэмжээний тэлэлт хязгаарлаж байна. Тухайлбал, Төв банкнаас үзүүлж буй төсвийн шинжтэй дэмжлэг (орон сууцны хөнгөлөлттэй зээл гм.), төрийн өмчит үйлдвэрийн газруудын төсвөөс гадуур хийж буй хөрөнгө оруулалт бодлогын үр нөлөөг хязгаарлаж байна. Дотоодын эрэлтийг тогтворжуулах, улмаар гадаад цочролын нөлөөнд байгаа инфляц, ханшийн дарамтыг бууруулахад харилцан уялдаатай бодлого хэрэгжүүлбэл илүү үр дүнтэй.

Валютын ханшны уян хатан бодлого, худалдаа ба гадаадын хөрөнгө оруулалтыг сэргээх бодлого нь Монгол Улсын валютын нөөцийг нэмэгдүүлж, төлбөрийн тэнцэлд ирж буй дарамтыг бууруулахад тустай. *Богино хугацаанд хэрэгжүүлэх бодлого:* Валютын ханшны уян хатан бодлого нь импортыг хазаарлаж, ханшийн уналтын хүлээлтийг сулруулах ба энэ нь Төв банкны валютын (маш багассан) нөөцийг хамгаалахад тусална. Мөн, төлбөрийн тэнцэлд ирэх дарамтыг бууруулахын тулд авах зайлшгүй арга хэмжээ бол төсөл хөтөлбөрийг эрэмбэлэн сонгож хэрэгжүүлэх (импортын өсөлтөөс сэргийлэх арга) явдал мөн. *Дунд хугацаанд хэрэгжүүлэх бодлого:* Гадаад худалдааг хөнгөвчлөх, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого, эрх зүйн орчныг бүрдүүлбэл Монголын экспортыг илүү өрсөлдөхүйц болгох, валютын нөөцийг сэргээн нэмэгдүүлэх, гадаад цочролыг тэсвэрлэх чадавхыг дээшлүүлэх, зах зээлд итгэх итгэлийг сэргээхэд чухал үүрэг гүйцэтгэнэ.

Хувийн хэвшлийн динамик хөгжил, инновацыг дэмжихүйц бизнесийн орчныг бүрдүүлж, илүү чанартай ажлын байруудыг бий болгох

Бизнесийн үйл ажиллагааг дэмжих бодлого, эрх зүйн орчны тогтвортой байдлыг хангах богино ба урт хугацааны арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхийг эрмэлзэх нь зүйтэй. Үүнд: эрх зүйн зохицуулалтын тодорхой бус байдлыг багасгахын тулд зохицуулалтын хяналтын зөвлөлийг бий болгох, зохицуулалтын орчин дахь саад хязгаарлалтыг тодорхойлох, төр, хувийн хэвшлийн харилцаанд нээлттэй суваг бий болгох зорилгоор төр, хувийн хэвшлийн үр дүнтэй яриа хэлэлцээг тогтмол өрнүүлэх, холбогдох хууль тогтоомж, хэм хэмжээг олон нийтээр зайлшгүй хэлэлцүүлдэг жишгийг тогтоох зэрэг арга хэмжээ багтана.

Шударга, өрсөлдөөнт бизнесийн орчныг дэмжсэнээр аж ахуйн нэгжүүд илүү инновацтай, бүтээмжтэй болон хөгжих бололцоог тэлнэ. Нийт эдийн засгийн хэмжээнд болон салбар бүрд өрсөлдөөнийг дэмжих төрийн бодлого шаардлагатай байна. Жишээлбэл, худалдан авах ажиллагаанд мөрдөх дүрэм, шалгуур нөхцөлийг уялдаатай болгох, төрийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулснаар олон аж ахуйн нэгж зах зээл дээр бий болж, төрийн худалдан авах ажиллагаатай холбоотой маргаан зөрчлийг бууруулна. Түүнчлэн, голлох бус салбарт үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчит байгууллагууд зах зээлд шинэ тоглогч (инновац дагаж) орж ирэхэд чөдөр тушаа болж байгааг залруулах шаардлагатай. Мөн, өмчлөх эрхийг зөвшөөрч хүндэтгэх явдал инновацыг дэмжих хөшүүрэг болдог.

Санхүүгийн салбарын найдвартай ажиллагаа нь бизнесийн, ялангуяа жижиг, дунд үйлдвэрийн хөгжлийг дэмжинэ. Зээлийн мэдээллийн системийг сайжруулснаар ил тод байдал нэмэгдэж, хөдлөх хөрөнгийг илүү үр ашигтайгаар буюу барьцаа хөрөнгө болгон ашиглах боломж нэмэгдэж, аж ахуйн нэгж зээл авах боломж дээшилнэ. Үүнээс гадна Монгол Улс дампуурал зарлах, дампуурсан аж ахуйн нэгж зээлдүүлэгчдэдээ төлөх өр зээлийн асуудлаа шүүхээс гадуур шийдэх арга механизмыг боловсронгуй болгох шаардлагатай юм.

Лиценз, зөвшөөрөл олгох ажиллагааг нэгдмэл, энгийн хялбар системд оруулбал аж ахуйн нэгжийг үүсгэн байгуулах, үйл ажиллагааг нь өргөжүүлэхэд дөхөмтэй байх болно. Шинэ сэргэлтийн бодлогын 6-р зүйлд Засгийн газар төрийн хяналт шалгалтыг цэгцэлж, төрийн эрх бүхий байгууллагаас шаарддаг тусгай зөвшөөрөл, техникийн нөхцөлийг хялбарчлах зорилтыг тусгасан байна. Үүнээс гадна бүх лиценз, зөвшөөрлийг цахимаар бүртгэж сан үүсгэх, уг бүртгэлийг олон нийтэд нээлттэй болгохыг зөвлөж байна.

Уул уурхайгаас бусад салбарын экспортын нэр төрлийг нэмэгдүүлж, хэлбэлзэл багатай шинэ салбаруудад ажлын байр бий болгох

Худалдааг хөнгөвчлөх, тээвэр логистик, хорио цээрийн стандарттай холбоотой сул талуудаа шийдвэрлэж чадвал импортын түүхий эд, материалын нийлүүлэлт нэмэгдэж, үйлдвэрлэгчид дэлхийн нэмүү өртгийн сүлжээнд нэгдэх боломж нэмэгдэнэ. Тухайлбал, төрөөс хил дамнасан худалдааг дэмжихэд анхаарч, хилийн шалган нэвтрүүлэх хугацаа, өртөг зардлыг бууруулах нь зүйтэй. Гаалийн бүрдүүлэлтийг автоматжуулж, хилийн бүх хяналт шалгалтын цэгүүд дээр тээвэрлэлтийн баримт бичиг бүрдүүлэх, төлбөр төлөх ажиллагааг цахимжуулах замаар энэ шинэчлэлийг хийх боломжтой. Логистикийн өндөр-чанартай дэд бүтцийг (төсвийн үр ашигтай хөрөнгө оруулалтаар) барьж байгуулан, хорио цээрийн стандарт, хяналтын ажиллагааг боловсронгуй болговол (гол боомтууд дээр хорио цээрийн хяналтын цэг байгуулах) Монголын аж ахуйн нэгжүүд дэлхийн өртгийн сүлжээнд оролцоход нь дэмжлэг болох юм.

Хөрөнгө оруулалтын эрх зүйн орчныг сайжруулснаар уул уурхайгаас бусад салбарт ГШХО татах боломжтой. Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт өөрчлөлтийг оруулах, ГШХО-ыг хориглох салбар, үйл ажиллагааны нэгдсэн жагсаалт гаргах замаар хөрөнгө оруулалтыг дэмжих, хөрөнгө оруулагчийг хамгаалахад ахиц гаргах шаардлагатай юм.

Ажиллах хүчний ур чадварыг дээшлүүлэх

Өнөөгийн болон ирээдүйд шаардлагатай мэргэжлийн ур чадварын хэрэгцээ шаардлагыг хангахын тулд Монголын боловсрол сургалтын системийг чадавхжуулж, сайжруулах шаардлагатай.

Боловсрол, ур чадварын тогтолцооны чанар, уялдааг сайжруулах

Хөдөлмөрийн зах зээлийн талаарх илүү тодорхой, чанартай мэдээлэл бий болсноор их, дээд болон мэргэжлийн боловсролын байгууллагууд сургалтын хөтөлбөрөө зах зээлийн эрэлт, шаардлага, улс орны хөгжлийн тэргүүлэх чиглэлтэй нийцүүлэхэд дөхөмтэй болно. Ажил эрхлэлтийн чиг хандлага, ур чадварын нийцэл/эс нийцэл, өөрсдийнхөө сургалтын хөтөлбөрийн уялдааг тодорхойлохын тулд их, дээд сургууль (ИДС), техникийн ба мэргэжлийн боловсролын байгууллагууд (ТМББ) хөдөлмөрийн зах зээлийн

нөхцөл байдлын талаар байнга судалж, ажил олгогч, холбогдох талуудтай зөвлөлдөж ажиллах шаардлагатай байна.

Боловсролын байгууллага ба хөдөлмөрийн зах зээлийн уялдааг сайжруулахад чиглэсэн санхүүгийн хөшүүргийг нэвтрүүлэх боломжтой. ИДС, ТМББ-ууд сургалтын хөтөлбөр, элсэлтээ хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, улс орны хөгжлийн тэргүүлэх чиглэлтэй нийцүүлэхийг урамшуулсан санхүүгийн дэмжлэгийг нэвтрүүлэх боломжтой юм.

Ур чадварыг хөгжүүлэх зорилгын төлөө хувийн хэвшилтэй бодитой түншлэлийг хөгжүүлэхэд Засгийн газрын зүгээс анхаарах хэрэгтэй байна. Үндэсний, салбарын болон байгууллагын түвшинд төрөл бүрийн зөвлөлдөх бүтэц байдаг ч гэлээ тэдгээр нь *de facto* гэхээс илүүтэй *de jure* түншлэлийн шинжтэй бөгөөд, тэдгээр бүтцийн гаргасан шийдвэрийг Засгийн газрын зүгээс хянадаг тогтолцоотой. Сургуулиуд үйлдвэрлэлийн салбаруудтай үр дүнтэй түншлэх арга механизм төлөвшиж чадаагүй байна. Мэргэжлийн болон салбарын холбоодын статус, эрх, хариуцлагыг хуулиар тогтоох замаар хувийн хэвшлийн оролцоог дэмжих нь зүйтэй. Ингэснээр мэргэжлийн холбоод салбарын болон үндэсний түвшний зөвлөлдөх бүтэц, томоохон хэмжээний хөгжлийн төсөл, судалгааны зөвлөлд орж, хамтран ажиллан, ажил мэргэжлийн стандартыг боловсруулах, сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох, байгууллагын болон хөтөлбөрийн гүйцэтгэлд үнэлгээ хийхэд хувь нэмрээ оруулах бололцоотой болно.

Дадлага хийлгэх, багаар ажиллахыг сургах, ажилд зуучлах зэргээр оюутнуудыг ажлын байр, хөдөлмөрийн зах зээлтэй холбож, төгсөгчдийн сургуулиас ажилд шилжих шилжилтийг хөнгөвчлөх нь зүйтэй. Одоогийн байдлаар ИДС, ТМББ-ын алинд нь ч ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, дадлага хийлгэх, баг болж хамтран суралцах, ажилд зуучлах зэрэг оюутныг хөдөлмөрийн ертөнцтэй холбох үйлчилгээ, хөтөлбөрүүд хангалттай биш байна. Боловсролын байгууллагууд багийн ажиллагаанд суурилсан сургалт, өөрийн биеэр хийж турших сургалт зэрэг сургалтын уян хатан хувилбар, сонголтыг оюутнуудад санал болгох, зах зээлд хамгийн эрэлт хэрэгцээтэй байгаа зөөлөн ур чадвар (бусадтай харилцах ба багаар ажиллах чадвар), танин мэдэхүйн чадвар (эргэцүүлэх сэтгэлгээ, дүгнэх, төлөвлөх ур чадвар), мэргэжлийн ур чадвар (гадаад хэлний мэдлэг гэх мэт)-ыг нь хөгжүүлэх, туршлага хуримтлуулах бололцоо олгох хэрэгтэй байна. Эдгээр шинэчлэлийг хэрэгжүүлэхэд байгууллагын илүүтэй бие даасан байдал шаардагдана.

Төрөөс ажил олгогчидтой хамтран ажил мэргэжлийн стандартыг боловсруулах арга замыг эрэлхийлэх нь зүйтэй. Энэ нь техник, мэргэжлийн боловсрол, сургалтын хөтөлбөрийн нийцэл, чанарыг сайжруулахад онцгой ач холбогдолтой. Мөн сургалтын байгууллагууд ажил мэргэжлийн стандарт эсвэл ажил олгогчийн шаардлагад нийцсэн, чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх чадавхаа нэмэгдүүлэх шаардлагатай. Техник, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагууд мөн ажил олгогчидтой үр дүнтэй хамтран ажиллаж, зөвлөлдсөний үндсэн дээр суралцагч, төгсөгчдийн ур чадварын дутагдлыг тодорхойлж, сургалтын хөтөлбөр, дадлага, ажлын байран дээрх сургалтаа байнга сайжруулж байх хэрэгтэй юм.

Нийгмийн халамжид хамрагдсан иргэдийн ажил эрхлэх боломжийг нэмэгдүүлэх

Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ нь нийгмийн халамжид хамрагдагсдыг ажилтай болоход чухал үүрэг гүйцэтгэдэг. Зөвлөгөө өгөх, ажил хайхад дэмжлэг үзүүлэх зэрэг зуучлалын үйл ажиллагаа, хөдөлмөр эрхлэлтийн өмнөх сургалт, мэргэжлийн сургалт, ажлын

байран дээрх сургалт, зуучлал, зөвлөгөө, цалингийн татаас зэрэг ХЗЗИХ-үүд нь нийгмийн халамжид хамрагдагсдын чадавх, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх боломжтой. Бүтээмжтэй хувиараа хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр нь цалинтай ажлын байрны хомсдолтой хөдөө орон нутагт амьдарч буй иргэдэд ач тустай байдаг.

Гэвч хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээг зорилтот нийгмийн үйлчилгээтэй хавсарсан тохиолдолд хамгийн үр дүнтэй байдаг. Нийгмийн халамжид хамрагдсан, хөдөлмөрийн зах зээлд бараг оролцдоггүй иргэд ажил эрхэлье гэхэд олон давхар саад бэрхшээл тулгардаг. Тиймээс тэдний хувьд асуудлаа шийдэхэд хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ дангаараа хангалтгүй байх нь олонтоо⁶. Иргэд халамжаас хөдөлмөрийн зах зээлд шилжихэд нэмэлт үйлчилгээнүүд шаардлагатай байдаг. Тухайлбал, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний байгууллагууд тухайн иргэдийг хэрэгцээнийх нь дагуу хүүхдийн асаргаа хөгжлийн үйлчилгээ, өндөр настны асаргаа, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний төлбөрөөс чөлөөлөлт, санхүү, орон байрны дэмжлэг, нийтийн унааны төлбөрийн дэмжлэг, архидалт, донтолтоос салгах сэтгэл зүйн зөвлөгөө, иргэний бичиг баримт сэргээх зэрэг олон үйлчилгээтэй холбодог байх асуудлыг богино ба дунд хугацаандаа авч үзэх нь зүйтэй. Гэхдээ эдгээр үйлчилгээг хөгжүүлэх, чанарыг нь дээшлүүлэх хэрэгтэй бөгөөд үүнд цаг хугацаа, хөрөнгө нөөц шаардагдана. Тухайлбал, байнгын асаргаа шаардлагатай иргэдэд зориулсан мэргэжлийн асаргааны үйлчилгээг хөгжүүлбэл асран хамгаалагч нь ажил хөдөлмөр эрхлэх боломжтой болно.

Нийгмийн халамжид хамрагдсан иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжихийн тулд ажилтай болсны дараа ч халамжийн тэтгэмжийн тодорхой хэсгийг үргэлжлүүлэн олгодог байж болох юм. Халамж авагчийн орлого нэмэгдэхэд тэтгэмжийг нь зогсоовол энэ нь ажил хөдөлмөр хийх сэдлийг үгүй болгоно. Харин тэтгэмжийн хэмжээг шат дараатай бууруулж олгосноор халамж авагч нь халамжийн хөтөлбөрөөс гарч, бие даахад нь дэм болно.

Халамжид хамрагдсан иргэдийн ажил хөдөлмөр эрхлэлтийг дэмжихийн тулд цогц, иргэний нөхцөл байдлыг харгалзсан аргачлалыг цаашид (урт хугацаанд) нэвтрүүлэх нь зүйтэй. Тухайн иргэнд тулгарсан хөдөлмөр эрхлэлтийн саад бэрхшээлийг арилгахын тулд кейс менежментийн аргачлалыг хэрэглэх шаардлагатай. Ийм аргачлалыг зөвхөн хувь хүнд төдийгүй тухайн өрхийг бүхэлд нь авч үзэн ашиглах боломжтой. Үүний тулд кэйс менежментийн арга хэрэгслийг боловсруулах, энэ аргачлалыг хэрэгжүүлэх нийгмийн ажилтнуудын чадавх, мэдлэг туршлагыг дээшлүүлэх шаардлагатай.

Халамжаас хөдөлмөрт шилжүүлэхийн тулд нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлтийн бодлогын зохистой уялдааг хангах хэрэгтэй. Цогц, кейс менежментийн аргыг хэрэгжүүлэхийн тулд бодлого, байгууллагын уялдаа холбоог хангах шаардлагатай байдаг. Халамж ба хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг төлөвлөх, хэрэгжүүлэх, иргэнд хүргэх бүхий л явцад институцийн аль ч түвшинд зүй зохистой зохицуулалт шаардагдана. Монгол Улс дараах гурван хувилбарын аль нэгийг сонгон хэрэгжүүлж болно. Үүнд, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг нийгмийн халамжийн тэтгэмжийн удирдлагатай нэгтгэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр ба орлогыг дэмжих хөтөлбөрийг уялдаатай хэрэгжүүлэх, зохицуулах чиг үүрэгтэй тусдаа бүтэц бий болгох, эсвэл хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн мэдээллийн нэгдсэн системийг бий болгох гэсэн гурван сонголтын аль нэгийг авч үзэж болно.

⁶ Хөдөлмөрийн зах зээлийг идэвхжүүлэх хөтөлбөрт хамрагдагч бусад иргэдэд ч бас энэ асуудал хамаатай. Учир нь ажилгүйчүүдийн хувьд хөдөлмөр эрхлэхэд нь олон саад бэрхшээл тулгардаг.

Хөдөлмөрийн зах зээлийн ажиллагааг сайжруулах

Хөдөлмөрийн бодлого, институцийн шинэчлэл нь хөдөлмөрийн зах зээл илүү үр дүнтэй, хүртээмжтэй ажиллахад нөлөөлдөг. Ажил олгогч таарч тохирох ажилтнаа цаг алдалгүй олж авах, ажил хайгчийн ажил хөдөлмөртэй болох чадавх, боломжийг дээшлүүлэх, ажилгүй иргэдэд орлогын дэмжлэг үзүүлэх чиглэлээр хийх шинэчлэл нь ажлын байр бий болгоход хувь нэмэр болдог.

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн цогц тогтолцоог хөгжүүлэх

Хөдөлмөрийн зах зээлийн чанартай мэдээллийн систем (ХЗЗМС) нь хөдөлмөрийн зах зээл үр дүнтэй ажиллах чухал урьдач нөхцөл мөн. Сайтар хөгжсөн ХЗЗМС нь олон талын хэрэглэгчийн хэрэгцээг хангахад чиглэгддэг. Хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл боловсрол сургалтын байгууллагад чухал ач холбогдолтойг өмнө дурдсан билээ. Эдгээрээс гадна ажил олгогч, ажил хайгч, оюутан, бодлого тодорхойлогчдод хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл байдал, ажиллах хүч, хөдөлмөрийн ба ур чадварын эрэлт, шаардлагын талаарх цаг хугацааны хоцрогдолгүй, бодитой мэдээлэл хэрэгцээтэй байдаг ба сайн мэдээлэл нь зөв шийдвэр гаргах боломж олгодог. Хэрэглэгчид хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн нөхцөл байдал, ирээдүйн чиг хандлагыг харуулсан, хялбар ойлгомжтой мэдээллийг онлайнаар авах боломжийг бүрдүүлэх зүйтэй. Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн өөр нэг чухал хэсэг бол төрөөс зохион байгуулж буй хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн хянах, үр нөлөөг үнэлэхэд шаардагдах мэдээлэл мөн.

Монгол Улсын ХЗЗМС-ийг боловсронгуй болгон хөгжүүлэх шаардлагатай байна. Өнөөгийн хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ)-наас хэрэгжүүлж буй үйлчилгээ, хөтөлбөрийг хянах хэрэгцээнд илүүтэй үйлчилж байна. Харин хөдөлмөрийн зах зээлийн одоогийн ба ирээдүйн чиг хандлага, тодорхой ажил мэргэжил, ур чадварын өнөөгийн ба цаашдын эрэлтийн талаарх мэдээлэл дутагдалтай байна.

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нээлттэй веб порталыг хөгжүүлэх, уг порталыг удирдах, мэдээллийг нийтлэх үүрэгтэй хөдөлмөрийн зах зээлийн ажиглалтын төв байгуулахыг зөвлөж байна. Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нээлттэй веб портал нь төрийн байгууллагын хэрэгцээнээс гадна төрийн бус хэрэглэгч, оролцогчдын мэдээллийн хэрэгцээг нэг цэгээр хангах зорилготой байна. Хөдөлмөрийн зах зээлийн ажиглалтын төв нь холбогдох өгөгдлийг цуглуулж, боловсруулалт хийх, хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл байдлыг ажиглан дүгнэх, мэдээллийг уг нээлттэй порталд байршуулах чиг үүрэгтэй байх юм.

Хөдөлмөрийн зах зээлийг идэвхжүүлэх хөтөлбөрүүдийг сайжруулах

Хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй хөтөлбөрүүд (ХЗЗИХ) нь ажил хайгчдыг, тэр дундаа хөдөлмөр эрхлэхэд илүү саад бэрхшээлтэй учирч байгаа ажил хайгчдад дэмжлэг үзүүлэх зорилготой байдаг. Эдгээр хөтөлбөр нь ажилд зуучлах, зөвлөн туслах, ажил хөдөлмөрт бэлдэх, ур чадвар олгох, хувиараа хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, цалингийн татаас олгох зэрэг дэмжлэг, арга хэмжээг багтаадаг. ХЗЗИХ-үүд нь ажилгүйдлийг бууруулах, ажлын байр бий болгох асуудлыг дангаараа шийдэх шидэт арга хэрэгсэл биш боловч тэдгээрийг үр дүнтэй боловсруулж, хэрэгжүүлбээс ажилгүйчүүд, бусад эмзэг бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн хэтийн төлөвийг сайжруулж чадна

Санхүүжилтийн тогтолцоо бэрхшээл дагуулдаг, арга хэмжээнүүдийн харьцаа зохистой бус, удирдлагын мэдээллийн системийн сул байдал нь Монгол Улсын ХЗЗИХ-үүдийн үр дүнг хязгаарлаж байна. ХЭДС нь нэлээд асуудалтай эх үүсвэр болох гадаад ажиллагчдын ажлын байрны төлбөрөөс хамааралтайгаас гадна ХЭДС-д санхүүжилт шилжүүлэх үйл явц яамд хоорондын уян хатан бус зохицуулалтын улмаас удаашралтай тул эрэлт хамгийн өндөр үед хөтөлбөрийн хэрэгжилт саатах нөхцөл байдал үүсдэг. Хөтөлбөрүүдийн бүрэлдэхүүн талаас авч үзвэл хувиараа хөдөлмөр эрхлэлтийг давамгайл дэмжиж, харин сургалтын үйл ажиллагааг бага анхаарч байна. Үүнээс гадна сургалтын хугацаа хэт богино, ур чадвар олгох олгоход бодитой нөлөөлөхгүй байна. ХЗЗИХ-ийг сайн хөгжүүлсэн улс орнууд ур чадварын сургалтад гол анхаарлаа хандуулдаг бөгөөд сургалт нь илүү урт хугацаатай, ажил олгогч болон ажлын байртай нягт холбоотой хэрэгждэг. Түүнчлэн, ХЗЗИХ-ийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо сул хөгжсөн. Ажил хайгч болон хөтөлбөрт хамрагдагсдын шинж байдлын талаарх болон хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл хязгаарлагдмал, хөтөлбөрүүдийн үр дүнг хөтөлбөрт хамрагдсаны дараах ажил эрхлэлт зэрэг бодит үр нөлөөг хэмжих үзүүлэлтээр үнэлэх нь дутмаг байна.

Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний (ХЭҮ) чадавх хязгаарлагдмал. Хангалттай санхүүжилттэй, сайтар бэлтгэгдсэн хүний нөөц бүхий хөдөлмөр эрхлэлтийн албад бол хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй хөтөлбөрүүдийн амжилтад хүргэх чухал түлхүүр юм. Эдүгээ сум, хорооны түвшний ажилтан нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг давхар хариуцдаг тул тэдний ажлын ачаалал ихээх гадна “ажил хайгчийн үнэлгээ (профайлинг)” зэрэг хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний хамгийн сүүлийн үеийн арга туршлагыг нэвтрүүлэхэд сайтар бэлтгэгдээгүй байна. ХЭҮ-г ажил хайгч болон ажил олгогчдын аль алиных нь эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн хөгжүүлэх шаардлага тулгамдаж байна. ХНХЯ нь зөвшөөрөл авсан хувийн хөдөлмөр зуучлалын байгууллагатай хамтран ажилладаг ч, захиргааны процесс нь амаргүй гэж үздэг тул нэлээд олон хувийн байгууллагууд бие даан, голчлон ур чадвар өндөртэй үйлчлүүлэгчдийг татсан үйлчилгээ эрхэлж байна.

Дээрх асуудлыг шийдэхэд дараах арга хэмжээг зөвлөмж болгов. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль тогтоомжоо шинэчлэхдээ ХЗЗИХ-ийн санхүүжилттэй холбоотой бэрхшээл, ялангуяа ХЭДС-д санхүүжилтийг цаг алдалгүй шилжүүлэх шаардлагыг тодорхой зохицуулах шаардлагатай байна. Монгол Улс хотжиж, хөдөлмөр эрхлэлт албан салбарт төвлөрөхийн хэрээр, хот суурин газрын хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээ шаардлагыг хангахад чиглэсэн ур чадварын хөтөлбөрийг чухалчлах хэрэгтэй байна. Тухайлбал, сургалтын хөтөлбөрийг эрэлтэд нийцүүлж, ажлын байртай нягт уялдаатай хэрэгжүүлэх шаардлагатай. Өөр нэг чухал асуудал нь ХЗЗИХ-үүдийг системтэй хянах, үнэлэх тогтолцоог хөгжүүлж, дээр дурдсан ХЗЗМС-ийг нэг бүрэлдэхүүн хэсэг нь болгох нь зүйтэй. Эцэст нь ХЗЗИХ-ийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд ажил хайгчид зөвлөгөө өгөх, ажил эрхлэлтийн төлөвлөгөө гаргахад туслах чадавхыг дээшлүүлэх шаардлагатай байна. Үүний тулд ажилтнуудын чадавхыг дээшлүүлэх, ажил хайгчийг үнэлэх арга хэрэгслийг боловсруулах, зуучлалын онлайн порталыг хөгжүүлэх, үйлчилгээг цахимжуулахад хөрөнгө оруулах, хөдөлмөр эрхлэлт, халамжийн үйлчилгээний тэнцвэр, уялдаа холбоог үр дүнтэйгээр хангах шаардлагатай юм.

Ажилгүйдлийн даатгалыг боловсронгуй болгох, ажилтны хамгааллыг сайжруулах

Ажилгүйдлийн даатгалд албан секторын цалин хөлстэй ажиллагч хамрагддаг, даатгалын хамрах хүрээ өргөн боловч ихэнх ажилгүй болсон хүмүүс тэтгэмж авч чаддаггүй. Ажиллах хүчний дөрөвний гурав орчим нь нийгмийн даатгалын шимтгэл төлж, ажилгүйдлийн даатгалд хамрагддаг хэдий ч ажилгүйчүүдийн тавны нэг орчим нь

л ажилгүйдлийн тэтгэмж авах эрх үүсгэдэг. Эдүгээ ажилгүйдлийн даатгалын тогтолцоо нь хамрагдалт, тэтгэмжийн зохистой хэмжээг хангах асуудлыг шимтгэл төлөх чадвар, тэтгэмжийн зардлыг хазаарлах асуудлаас илүү чухалчилж байна. Улирлын шигж чанартай ажил эрхэлж, шимтгэл төлдөг даатгуулагчид өнөөгийн тогтолцоо хатуу хандаж байгаагаас гадна тэтгэмжийн хугацаа харьцангуй богино байна. Ажилгүйдлийн тэтгэмжийг ажил байнга хайж буй эсэхтэй (идэвхжүүлэх хөтөлбөр) холбох холбоос сул. Ажилгүйдлийн тэтгэмж авч буй иргэн ажил идэвхтэй хайсаар байх шаардлагыг хатуу мөрдүүлдэггүйгээс тэдэнд зориулсан хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, хөтөлбөр цөөн байна.

Бодлого тодорхойлогчид ажилгүйдлийн даатгалын хүрээнд олгох дэмжлэгийг нэмэгдүүлэх талаар судалж үзэх нь зүйтэй. Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг есөн сар тасралтгүй төлсөн байх шаардлага нь Монголын эдийн засгийн идэвхжилийн мөчлөг, улирлын чанартай хөдөлмөр эрхлэлтийн онцлогийг харгалзахгүй байгаа тул уг шаардлагыг зөөллөх шаардлагатай юм. Түүнчлэн, ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг нэмэгдүүлэх, ажилгүйдлийн тэтгэмж авах хугацааг уртасгах асуудлыг актуар тооцоолол хийсний үндсэн дээр судлан үзэж боломжтой. Ажилгүйдлийн тэтгэмж авагчдыг идэвхжүүлэх үйлчилгээнд хамруулж, тэдний өмнө тулгарч буй хөдөлмөр эрхлэлтийн саад бэрхшээлийг даван туулахад нь дэмжлэг үзүүлэх нь зүйтэй.

Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлд тулгарч буй сорилтуудын цаадах учир шалтгаан олон талтай. Тиймээс ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх бодлого нь олон салбарыг хамарсан, "Засгийн газар – бүхэлдээ" гэсэн зарчмыг эрхэмлэхийг шаардаж байна. Ажлын байрыг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн хүртээмжийг дээшлүүлэхэд ХНХЯ болон ажиллах хүчний хөгжлийн асуудал хариуцсан яамдын хүчин чармайлт чухал. Үүний зэрэгцээ, хувийн хэвшлийн хөгжил, шинэчлэлийг дэмжих эдийн засгийн бодлогыг хариуцсан яамдын үүрэг ч мөн маш чухал билээ.

Ашигласан эх сурвалж:

- Бетчерман, Г., М.Жалил нар, 2022. Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийг жиших, ажлын байрны боломжит эх үүсвэрийг тодорхойлоход Өсөлтийг тодорхойлох хүрээг ашиглах нь. Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн дүн шинжилгээнд зориулсан үндсэн тайлангийн төсөл. Дэлхийн Банк, Вашингтон, ДС.
- Финстра, Р.К., Р. Инклаар, М.П. Тиммер нар. 2015. "Пенний дэлхийн хүснэгтийн дараачийн үе". *Америкийн эдийн засгийн судалгааны тойм* 105 (10): 3150–82. <https://www.ggd.net/pwt>."
- Дэлхийн Банк. Ажлын байр ба бүтцийн өөрчлөлтийн Стата хэрэгсэл, Ажлын байрны үзүүлэлтийн өгөгдлийн сан, Дэлхийн Банк, Вашингтон ДС, (татаж ашигласан огноо: 2021 оны 9 дүгээр сар), <https://datacatalog.worldbank.org/search/dataset/0037526>
- Дэлхийн Банк. 2016. *Урт насалж, удаан жаргах нь: Зүүн Ази, Номхон далайн бүс дэх насжилт*. Вашингтон, ДС: Дэлхийн Банк. <https://openknowledge.worldbank.org/handle/10986/23133>.
- Дэлхийн Банк. 2020б. *Уул уурхай ба оюун ухаан: Байгалийн баялгийн өгөөжийг институт болон хүний хөгжилд чиглүүлэх нь*. Монгол Улсын эдийн засгийн тойм. Дэлхийн Банк, Улаанбаатар. <https://openknowledge.worldbank.org/handle/10986/34551>

Тэмдэглэл

Тэмдэглэл

